

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМЫН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ,
САНАЛ, ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2020 ОНЫ
3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН**

2020.09.21

Лүн

Тус сумын Засаг дарга болон түүний Тамгын газарт 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 209 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирсэн байна. Сумын Засаг даргад 19 өргөдөл, Тамгын газарт 190 өргөдөл бичгээр ирснийг хүлээн авч холбогдох албан тушаалтанд танилцуулж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, хариуг бичгээр болон утсаар гарган мэдэгдэж, хүргүүлэн ажиллаж байна.

Нийт 206 өргөдөл, гомдлыг 15 хоногийн хугацаанд нь, 1 өргөдлийг хугацаа хоцроож 100 хувь шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.

Ирсэн өргөдөл, гомдлыг ангилбал:

1. Иргэний бүртгэлтэй холбоотой – 174
2. Буцалтгүй тусламж, эмчилгээний зардал, тэтгэмж хүссэн – 12
3. Газрын асуудалтай холбоотой – 3
4. Ажлын байртай холбоотой – 4
5. Орон гэртэй холбоотой – 2
6. Чөлөө хүссэн – 1
7. Бусад – 13

Газрын асуудлаар хандсан 3 өргөдлийг судалж 2 иргэний газрын захирамж гаргуулах, 1 иргэний өвөлжөөний газартай холбоотой хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн. Ажлын байртай холбоотой 4 өргөдлийг судалж, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх 3 албан хаагчийг чөлөөлж, ажилд орох хүсэлтэй 1 иргэнийг ажилд томилсон. Эмчилгээний зардал, буцалтгүй тусламж, тэтгэмж хүссэн 12 өргөдлийг судлан үүнээс 7 өргөдлийн дагуу албан хаагчдад 1.400.000 төгрөгийн тэтгэмж олгож, 5 өргөдлийн дагуу иргэдэд 1.550.000 төгрөгийг олгов. Чөлөө хүссэн 1 өргөдлийг судлан хүүхэд асрах чөлөөг 1 жилээр сунгасан. Орон гэртэй холбоотой 2 өргөдлийг судлан 1 өргөдлийг аймгийн Засаг даргын орлогчид уламжлан дахин 15 хоногоор шийдвэрлэх хугацааг сунгасан. 1 өргөдөл нь шийдвэрлэх шатандаа явж байна. Бусад асуудлаар хандсан 13 өргөдлийг судлан жирэмсний амралт олгож, дэмжлэг хүссэн тодорхойлолт, өөрийн эзэмшлийн газар худаг гаргах хүсэлтийг холбогдох газарт нь уламжилсан тодорхойлолтуудыг гарган

шийдвэрлэсэн. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрөл сунгах болон шинээр авах хүсэлтийг тус тус шийдвэрлэсэн. 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байна.


Иргэний шилжилт хөдөлгөөн, улсын бүртгэлтэй холбоотой 174 өргөдөл, гомдол ирснийг 100 хувь шийдвэрлэсэн байна.

Иргэний шилжилт хөдөлгөөн, улсын бүртгэлтэй холбоотой 174 өргөдлийг ангилбал:

- Төрсний бүртгэл – 10
- Цахим үнэмлэх шинэ, сунгалт – 33
- Цахим үнэмлэх олголт – 51
- Шилжилт хөдөлгөөн – 77
- Бусад – 3

Цахим сүлжээгээр, утсаар, амаар гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлт байхгүй болно.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  В.ГАНТУЯА

ТАЙЛАН ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ  Д.СУВД-ЭРДЭНЭ

Баянтал сумын 2020 оны 3 дугаар улирлын өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэлтийн байдал

20.09.21

| № | Тайлан ирүүлсэн сум | Нийт ирсэн өргөдөл, санал, гомдлын тоо | Шийдвэрлэлт | | | | Шийдвэрлэлт /хувь/ |
|---|---------------------|--|------------------------------------|-------------------------------|-------------------------------|------------------|--------------------|
| | | | Хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн | Бусад байгууллагад шилжүүлсэн | Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн | Хугацаа болоогүй | |
| 1 | Баянтал сумын ЗДТГ | 209 | 206 | | 1 | 2 | 98,56% |

| № | Байгууллагын нэр | Нийт ирсэн өргөдөл, санал, гомдол, хүсэлт | Үүнээс | | | | |
|--------------------|--------------------|--|---------|--|------------------------|-------------------------|---|
| | | | Бичгээр | Цахим хэлбэрээр /www.bayantal.gs.gov.mn/ | Утсаар хандсан /11-11/ | Биечлэн уулзсан /амаар/ | Бусад /иргэдтэй ажиллах, нээлттэй өдөрлөгөөр/ |
| 1 | Баянтал сумын ЗДТГ | 209 | 209 | | | | |
| Баянтал сумын ЗДТГ | | Зонхилж байгаа асуудал өргөдөл, гомдол | | | | Нийт тоо | Эзлэх хувь |
| | | 1. Иргэний бүртгэл шилжилт хөдөлгөөнтэй холбоотой | | | | 174 | 83,25% |
| | | 2. Буцалтгүй тусламж, эмчилгээний зардал, тэтгэмж хүссэн | | | | 12 | 5,74% |
| | | 3. Бусад | | | | 13 | 6,22% |
| | | 4. Ажлын байртай холбоотой | | | | 4 | 1,91% |
| | | 5. Газрын асуудалтай холбоотой | | | | 3 | 1,44% |
| | | 6. Орон гэртэй холбоотой | | | | 2 | 0,96% |
| | | 7. Чөлөө хүссэн | | | | 1 | 0,48% |

Тайлан хянасан:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

В.ГАНТУЯА

Тайлан бичсэн:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Д.СУВД-ЭРДЭНЭ

